

# ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ГЭРЭЭ

2024 оны ..... сарын ..... өдөр

Улаанбаатар хот

## Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Суралцах гэрээг нэг талаас Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьсаа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийг төлөөлж захирал Баатарцэнд овогтой Баяржахлан /цаашид сургууль гэх/ негэв талаас суралцагч ..... овогтой ..... /цаашид суралцагч гэх/ нар харилцан тохирч Монгол Улсын Иргэний хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, ШУТИС-ийн дүрэм болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг үндэслэн байгуулав.
- 1.2 Энэ гэрээгээр сургууль, суралцагчийн хорондын харилцааг зохицуулах ба талууд эрх, үүргийг адил хулзэнэ.
- 1.3 ШУТИС-д злсэх болзлыг хангасан (зцэг/эх-ийн нар) ..... -ын .....-г тус сургуулийн бакалаврын сургалтад хетэлбереер суралцуулахаар тохиролцов.
- 1.4 Гэрээний нийт хугацаа 5 /таван/ хичээлийн жил байх бөгөөд сургуулийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаан (суралцагч жилийн чөлөө авах, цуглуулах багц цагийн түйцэтгэл биелээгүй, үнэлгээний голч дүн хангалттай байх болон бусад)-аар гэрээний хугацаа сунгагдаж болно.

## Хоёр. Сургуулийн хүлээх үүрэг

- 2.1 Бакалаврын түвшний батлагдсан хетэлбериийн дагуу сургалтын үйл ажиллагааг цахим, танхим, хосолсон хэлбэрээр зохион байгуулж дээд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, тэгссен суралцагчид боловсролын зэрэг, дээд боловсролын диплом, энгэрийн тэмдэг олгох;
- 2.2 Сургалт явуулахад шаардлагатай эрүүл, аюулгүй, хүртээмжтэй орчин (хичээлийн байр, спорт заал, номын сан, анги, танхим, лаборатори, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бусад хэрэглэгдэхүүн)-ыг бурдуулж үндсэн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх;
- 2.3 Суралцагчийн суралцах үйлтийн дээмжих зэвлэн туслах, хувь хүний хөгжлийц чиглэсэн спорт, урлаг, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулж хамруулах;
- 2.4 Суралцагч ШУТИС-ийн дүрэм, холбогдох бусад эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах, сургалтын цахим системүүдэд хандах, үйлчлүүлэх боломжийг бурдүүлэх;
- 2.5 Зохих болзлыг хангасан суралцагчийг холбогдох журмын дагуу зээл, тусlamж, тэтэлэгт хамруулах;
- 2.6 Суралцагчаас гаргасан хүснэгт, санал, гомдлыг шийдвэрлэх.

## Гурав. Сургуулийн эрх

- 3.1 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдхөх түвшинд суралцагчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах;
- 3.2 Суралцагчийн суралцах үйлд хяналт тавих, эзэмшсэн мадлэг, чадвар, хандлага төлөвшийн хүрсэн түвшинд үнэлгээ хийх, тухайн улираалд судлах хичээл, багц цагийн хэмжээг тогтоох;
- 3.3 ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн тогтоолоор баталгаажсан тухайн хичээлийн жолийн сургалтын төлберийн нэг багц цагийн үнэлгээг баримтлан сургалтын төлбөрөө төлхийг шаардах, сургалтын төлбөрөө хугацаанд нь төлеөгүй тохиолдолд хичээл сонголт хийлгэхгүй байх;
- 3.4 Сургалтын төлберийн болон бусад төлбөр тооцроо сургуульд үүстгэх, нэхэмжилсэн хугацаанд авлагыг барагдуулаагүй тохиолдолд асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх;

## Дөрөв. Суралцагчийн хүлээх үүрэг

- 4.1 ШУТИС-ийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг мөрдөх, "Сургалтын нэгдсэн хуанли"-ийн дагуу суралцах үйл ажиллагаагаа төлөвлөж, хэрэгжүүлэх, сургалтын хетэлбериийн хичээлийн агууллыг бүрэн эзэмших, бие даан суралцах;
- 4.2 Хичээл сонголт-2 хийхийн ёмне сургалтын төлбөрөө бүрэн төлөх;
- 4.3 ШУТИС-ийн дүрэм болон бусад үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмуудыг мөрдөх сургууль, багш, ажилтнаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;;

- 4.4 Суралцагч хуулиар зөвшөөрөгдсөн хувийн мэдээллээс удирдлага мэдээллийн UNIMIS системд бүрэн бүртгэх, оршин суугаа хаяг, утасны дугаар зэрэг мэдээлэлд ворчилж орсон тохиолдолд тухай бүрд нь шинчлэх;
- 4.5 Суралцагч нь суралцах хугацаандав Европын олон хэлний стандарт (CEFR)-ын англи хэлний эзэмшил зохих В1 түвшний болзлыг хангасан байх;
- 4.6 Бусдын ялгаатай байдлыг хулээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр тэр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх, сургуулийн нэр хүчдэд үндэслэлгүй, хууль бусадар халдахгүй байх;
- 4.7 Боловсрол шинжлэх ухаан, Эрүүл мэндийн Сайдын 2023 оны А/273, А/314 тоот хамтарсан тушаалын дагуу эрүүл мэндийн даатгалaa заавал төлөх, үзлэг, шинжилгээнд хамрагдах;
- 4.8 Хуульд заасан бусад үүргүүд

**Тав. Суралцагчийн эрх**

- 5.1 Суралцах орчин, нехцел бололцоогоор хангуулах, сонгосон үндсан сургалтын хөтөлбөрөөс гадна хавсарга хөтөлбөрөөр суралцах, давхар мэргжжил эзэмших, иэлттэй сонгон болон ахисан түвшний хөтөлбөрөөс нэмэлтээр хичээл судлах, хичээл заах багшийг сонгох;
- 5.2 Чадамжийн үзүүлэлх, хулээн зөвшөөрүүлах, дүйцүүлэх, баталгаажуулах, гадаад, дотоодын их дээд сургуульд шилжин суралцах;
- 5.3 Сургалтын чанар, сургууль, багш, ажилтны үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, хүснэгт гаргах, зүй ёсны шаардлага тавих, шийдвэрлүүлэх;
- 5.4 Хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, хөнгөлөлттэд хамрагдах;
- 5.5 Сургуулиас зохион байгуулж буй эрдэм шинжилгээ, судалгаа инновац, урлаг, спорт, олон нийтийн бүх үйл ажиллагаанд хамрагдах, оролцох;
- 5.6 Хуульд заасан бусад эрхүүд

**Зургаа. Гэрээ цуцлах болон дуусгавар болгох**

- 6.1 Дараах нахцэлд энэхүү гэрээг аль нэг талын санаачилгаар цуцална. Үүнд:
  - 6.1.1 Суралцагчийн санаачилгаар (суралцагч гэрээ цуцлах өргөдлөө бимгээр гарган, "Тойрох хуудас"-аа бүрэн зуруулж, сургуулийн нягтлан бодогч "тооцоогүй" болохыг энэслэн баталгаажуулсан тохиолдолд);
  - 6.1.2 Сургуулийн санаачилгаар (ШУТИС-ийн дүрэм, журмыг зөрчсөн, "Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам"-д зааснаар суралцагчийн нэр "Анхааруулгын хуудас"-д Зулирал дараалан бичигдсан, сургалтын үйл явцыг орхиж З-аас дээш улирал "сураггүй" болсон, сургалтын төлбөрөө хугацаанд нь төлөөгүйгээс өр авлага үүссэн зэрэг шалтгаанаар суралцах гэрээг цуцлах тухай буралдахуун сургуулийн захирлын тушаал гарсан тохиолдолд);
- 6.2 Талуудын хооронд байгуулагдсан гэрээний заалт бүрэн хэрэгжиж, гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно.

**Долоо. Маргаан шийдвэрлэх**

- 7.1 Гэрээнээс үүдэлтэй аливаа маргааныг талууд баримт нотолгоо, учир шалтгаанд үндэслэн шийдвэрлэхийг эрмэлзэх ба зөвшилцэлд хүрч чадаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

**Найм. Бусад зүйл**

- 8.1 Энэхүү гэрээг хоёр тал гарын үсэг зурж, сургуулийн тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2 Сургууль, суралцагчийн аль нэг нь гэрээг цуцлах санал тавиагүй бол уг гэрээг хүчинтэйд тооцно.
- 8.3 Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

**Гэрээ байгуулсан:**

ШУТИС-ийг төлөөлж:

Өмнөөсөөсээс аймаг дахь Технологийн  
дээд сургуулийн захирал

Б.Баяржавхлан /...../  
/нэр/ /гарын үсэг/

Суралцагч:

/...../ /...../  
/нэр/ /гарын үсэг/

Харилцах утас: 99106175

Харилцах утас: .....